“ДУУТ НУУР” ХӨГЖИЛ ХХК-ИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР: 6709672/

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 5
1.1. Төслийн нэр 5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага 5
1.3. Төслийн байршил 5
1.4. Төслийн хүчин чадал, техник технологи 6
1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга 6
1.4.2. Төслийн техник технологи 7
1.4.3. Төслийн байрилга байгууламж, дэд бүтцийн шийдлийн мэдээлэл 10
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 15
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт 15
2.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 19
2.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт 21
2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт 21
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 22
ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 25
ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 26
5.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ 26
5.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ 27
5.3. Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ 28
ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 33
6.1. Энгийн хог хаягдлын менежмент 33
6.1.1. Хатуу хог хаягдал 33
6.1.2. Ахуйн шингэн хаягдал 34
6.2. Аюултай хог хаягдлын менежмент 36
ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 38
7.1. Агаарын чанарын хяналт, шинжилгээ 38
7.1.1. Судалгааны аргазүй 38
7.1.2. Судалгааны үр дүн 41
7.2. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ 42
7.2.1. Судалгааны аргазүй 42
7.2.2. Судалгааны үр дүн 43
7.3. Усны чанарын хяналт шинжилгээ 46
7.3.1. Судалгааны аргазүй 46

7.3.2. Судалгааны үр дүн 48
НАЙМ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 50
8.1. Ажиллагсдын ХАБЭА, эрүүл мэнд 50
8.2. Ажлын байрны галын аюулгүй байдал 51
8.3. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн олголт 52
8.5. Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажилласан байдал 53
ЕС. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 56
9.1 Хавсралт 58
9.2 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ 59
9.3 Газрын кадастрын зураг 61
9.4 Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ 62
9.5 Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ 63
9.6 Гаалийн хяналтын бүс тогтоосон тушаал 70
9.7 Агаарын шинжилгээний сорилтын үр дүн 71
9.8 Хөрсний шинжилгээний үр дүн 73
9.9 Усны шинжилгээний үр дүн 75
9.10 Аюултай хог хаягдал үүсгэгч, болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас 77

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил 5
Зураг 2. Төслийн ерөнхий төлөвлөлт 6
Зураг 3. Нүүрс ачилт буулгалт хийж буй байдал 7
Зураг 4. Ачилт буулгалтын талбайн харагдах байдал 7
Зураг 5. Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй дугуйт ачигч 8
Зураг 6. Бүрэн автомат усалгааны машин 8
Зураг 7. Авто пүү болон вагон пүү 9
Зураг 8. Авто пүү болон вагон пүүний баталгаажуулалт 9
Зураг 9. Талбайн камержуулалт 10
Зураг 10. Гаалийн хяналтын талбайн оффис, захиргааны байр 11
Зураг 11. Мобинет 11
Зураг 12. Авто пүүний ухаалаг гарц 12
Зураг 13. Ахуйн хэрэглээний усаар хангадаг зөөврийн худаг 12
Зураг 14. Савласан цэвэр ус ашиглалт 13
Зураг 15. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ 13
Зураг 16. Дулаан хангамжийн эх үүсвэр 14
Зураг 17. Харуулын байр 14
Зураг 18. Салхинаас хамгаалах хашаа засварласан байдал 15

Зураг 19. Усалгааны машин, зам талбай усалж буй байдал 16
Зураг 20. Төслийн талбайн тэмдэг тэмдэглэгээ 16
Зураг 21. 7173 УР дугуйт ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр 17
Зураг 22. 7174 УР дугуйт ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр 18
Зураг 23. 2461 УКУ усны машины үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр 18
Зураг 24. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав, бункер 19
Зураг 258. Авто машины зогсоол, усалгаа, дагтаршуулсан байдал 20
Зураг 3026. Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэг 20
Зураг 27. Хориглох тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал 21
Зураг 28. Төслийн талбайд байршуулсан гэрэлтүүлэг 22
Зураг 29. Сургалтанд хамрагдсан ажилтнууд 26
Зураг 30. Зааварчилгааны бүртгэлийн хуудас 27
Зураг 31. Галын сарай, гал унтраах багаж хэрэгсэл байрлуулсан байдал 27
Зураг 32. Галын аюулгүй байдлын дүгнэлт 28
Зураг 33. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны бүртгэл 29
Зураг 34. ХАБЭА-н зааварчилгаа өгч буй байдал 29
Зураг 35. Техник ашиглалтын паспорт, техникийн үзлэг, үйлчилгээний тэмдэглэл 30
Зураг 36. Анхны тусламжийн хайрцаг байршуулсан байдал 30
Зураг 37. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олгосон байдал 31
Зураг 38. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө 31
Зураг 39. Гамшгийн эрсдлийн үнэлгээ 32
Зураг 40. Хогийн сав (Цаас, хуванцар, бусад) 33
Зураг 41. Гадна талбайн ангилдаг хогийн бункер 33
Зураг 42. Хог хаягдлын гэрээ, ачилтын бүртгэл 34
Зураг 43. Эколос 6 ПР септик систем суурилуулалт 34
Зураг 44. Алтай эколос ХХК-ийн тусгай зөвшөөрөл 35
Зураг 45. Хог хаягдлын сургалтанд хамрагдсан байдал 36
Зураг 46. Аюултай хог, хаягдал түр хадгалах талбай 37
Зураг 47. Аюултай хог хаягдлын цэгийн хүлээлгэн өгөх хуудас 37
Зураг 48. Мониторингийн цэгүүдийн байршил 38
Зураг 49. Хээрийн судалгааны багаж 39
Зураг 50. Агаарын мониторингийн цэг 40
Зураг 51. Агаарын чанарын шинжилгээ хийсэн хэсэг /4 болон 9-р сар/ 41
Зураг 52. Хөрсний мониторингийн цэгийн байршил 43
Зураг 53. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Төслийн талбайн голд 4-р сар болон 9-р сар/ 44
Зураг 54. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Авто зогсоолын ойролцоо 4-р сар болон 9-р сар/ 45
Зураг 55. Усны мониторингийн цэгийн байршил 47
Зураг 56. Ахуйн усны дээжлэлт хийсэн хэсэг /2025 оны 4 болон 9-р сар/ 47
Зураг 57. Ойн ангийн худгийн усны дээжлэлт 48
Зураг 58. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулсан бичиг баримт 50
Зураг 59. Анхны тусламжийн хайрцаг 51

Зураг 60. Галын аюулгүй ажиллагааны самбар, галын дохиоллын систем, тэмдэг тэмдэглэгээ 52
Зураг 61. Ажлын хувцас хүлээлцсэн бүртгэл 53
Зураг 62. Хандивын гүйлгээний баримт 53
Зураг 63. Хог хаягдал цэвэрлэгээ, техникийн туслалцаа 53
Зураг 64. Гудамж, талбайн тэгшилгээний зураг 54
Зураг 65. Зам засварын ажил гүйцэтгэж буй явц 55
Зураг 66. Багийн иргэдийн нийтэд БОМТ хэрэгжилтийн мэдээлэл өгч буй нь 56

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд 5
Хүснэгт 2. Техникийн үзүүлэлт 35
Хүснэгт 3. Хэмжээнүүд 35
Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил 38
Хүснэгт 5. Агаарын чанарын мониторингийн цэг /Гадаад орчин/ 40
Хүснэгт 6. Агаарын шинжилгээний лабораторийн сорилтын дүн 41
Хүснэгт 7. Хөрсний мониторингийн цэгийн солбицол 42
Хүснэгт 8. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн 45
Хүснэгт 9. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд 46
Хүснэгт 10. Усны мониторингийн цэгүүдийн координат 47
Хүснэгт 11. Усны шинжилгээний аргачлал 48
Хүснэгт 12. Усны химийн шинжилгээний үзүүлэлтүүд 4/9 сар 48
Хүснэгт 13. 2025 онд зарцуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал 57

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Гаалийн хяналтын талбай” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: “Дуут нуур хөгжил” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 000255216
Регистрийн дугаар: 6709672
Хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, 4-75
Утас: 99138170 /Байгаль орчны мэргэжилтэн/

1.3. Төслийн байршил

Төсөл хэрэгжих талбай нь засаг захиргааны хуваарилалтаар Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, 1-р багийн нутаг дэвсгэрт, Аяган 100а хаягт 15.3 га талбайд байрлаж байна.

Төслийн талбай байрлах Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум нь Улаанбаатар хотоос 225 км-ийн зайтай оршино. Төслийн талбайн байршлыг дараах зургаар харууллаа.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгийн солбицолууд

Нэгж талбарын дугаар\талбайн хэмжээ, га	Цэгийн дугаар	Цэгийн солбицол	
		Өргөрөг	Уртраг

Нүүрс ачиж, буулгах талбай 15.3 га	1	5136067.79	295446.45
	2	5135962.62	295509.80
	3	5135838.23	295584.70
	4	5135895.17	295683.16
	5	5135770.48	295751.08
	6	5135635.81	295526.08
	7	5135623.74	295506.26
	8	5135550.98	295412.05
	9	5135872.75	295137.06
	10	5135943.16	295232.17
	11	5135946.32	295237.63
	12	5136067.59	295446.10

1.4. Төслийн хүчин чадал, техник технологи

1.4.1. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутаг Чойр өртөөг түшиглэн байгуулах Гаалийн хяналтын талбай нь Гааль, татварын ерөнхий газрын 2022 оны А/339 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн хяналтын бүсийн журам”, монгол улсын стандарт /MNS5832:2007/-ын шаардлага хангаж улс хооронд тээвэрлэх уул уурхайн эрдэст бүтээгдэхүүн хүлээн авах, хадгалах, ачиж буулгах, гаалийн хяналт хийхтэй холбогдсон иж бүрдэл үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Уламжлалт задгай тээвэр болон чингэлэгт тээвэрт ачиж гаалийн хяналтын бүсдээ хүлээн авч буулган гаалийн хяналт хийх үйл ажиллагаа эрхэлж байна.



Зураг 2. Төслийн ерөнхий төлөвлөлт

Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааны дараалал.

- Тээвэрлэж ирсэн ачаа бараа, тоног төхөөрөмж болон уул уурхайн эрдэст бүтээгдэхүүнийг стандарт журмын дагуу аюулгүй найдвартай зориулалтын талбайд буулгах
- Буусан ачаа бараа, тоног төхөөрөмж болон түүхий эдийг найдвартай стандартад нийцсэн талбайд хадгалах
- Талбай дахь ачааг чингэлэг ачиж буулгах ачигчаар ачиж пүүлүүлэн лацдаж, гаалийн хяналтад бүрдүүлэлт хийн гаргах.

Гэрээт компаниудын нүүрсийг гэрээнд заасны дагуу зөв буулгаж, вагонд ачиж экспортод гаргаж байна.

Зураг 3. Нүүрс ачилт буулгалт хийж буй байдал

Орон нутгийн ачаа бараа, тоног төхөөрөмж болон уул уурхайн эрдэст бүтээгдэхүүнийг чингэлэгт тээвэрт ачиж шууд эцсийн хэрэглэгчдэд хүргэж өгснөөр олон удаагийн ачиж буулгах явцыг багасгаж, үүнээс үүсэж буй материалын хорогдол, агаарын бохирдол, тоосжилт зэрэг байгаль орчны асуудлуудыг цогцоор нь шийдэх юм.

Зураг 4. Ачилт буулгалтын талбайн харагдах байдал

1.4.2. Төслийн техник технологи

Гаалийн хяналтын нүүрс буулгах талбайд доорх тоног төхөөрөмжийг ашиглахаар төсөлд тусгасан. Үүнд:

- Дугуйт ачигч /ковш/ - 2ш

- Чингэлэг буулгах болон ачих төхөөрөмж /KALMAR/ - 1ш
- Усны машин /ус тээвэрлэх – 1ш
- Суудлын автомашин – 1ш
- Вагон пүү – 1ш
- Авто пүү – 1ш

Эдгээрээс 2025 онд бид 2 дугуйт ачигч /SEM үйлдвэрийн/, 1 усны машин / ус тээвэрлэх /25 тоннын бүрэн автомат усны машин/, 2 суудлын машинтайгаар /Pruis 30/ үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 5. Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй дугуйт ачигч

Зураг 6. Бүрэн автомат усалгааны машин

Зураг 7. Авто пүү болон вагон пүү

Автопүү, вагонпүүг баталгаажилтын хугацаа дуусахаас өмнө тухай бүрд Стандарт хэмжил зүйн газрын байцаагчаар баталгаажуулж байна.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
АВТО МАШИНЫ ЖИНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ 0002933
Дуут нуур гөлчин ХХК -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа SCS загварын 200 Т
хэмжих хязгаартай, № 210,305 -ын
электрон, механик жинг № 089 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2025 оны 11 -р сарын 12 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.
Лабораторийн тэмдэг
Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг
2025 оны 05 -р сарын 12 -ны өдөр

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
МЕХАНИК ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ МЖ 078225
Дуут нуурын Хөгжил -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа SE-150 Ru загварын 150Т
хэмжих хязгаартай, № e=d=50кг -ын
Статик вагон ачаа -ыг
(хэмжих хэрэгслийн нэр)
№ 106 лацаар битүүмжилж оны 01 -р сарын 20 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.
Лабораторийн тэмдэг
Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг
2025 оны 01 -р сарын 20 -ны өдөр

Зураг 8. Авто пүү болон вагон пүүний баталгаажуулалт

Камер: Гаалийн байгуулган шарлагийн дагуу сүүлийн үеийн 16 камер байрлуулж гаалийн жинетик системтэй холбосон.

Зураг 9. Талбайн камержуулалт

“Дуут нуур хөгжил” ХХК нь дотор 3 ширхэг, гадна 24 ширхэг, 2 хөдөлгөөнт камер нийт 29 ширхэг камерийг суурилуулсан. Суурилуулсан камерууд нь 10x8 /80TB/ багтаамжтай байна.

1.4.3. Төслийн байрилга байгууламж, дэд бүтцийн шийдлийн мэдээлэл

Гаалийн хяналтын нүүрс буулгах талбайд доорх барилга байгууламжийг байгуулахаар төлөвлөсөн. Үүнд:

- Уламжлалт задгай болон чингэлэгтэй түүхий эд хүлээн авах, ачих, буулгах талбай
- Оффисын байр
- Орох болон гарах хаалганы шалган нэвтрүүлэх харуулын байр
- Авто пүү болон пүүлэгчийн байр
- Вагон пүү болон пүүлэгчийн байр
- Гаалийн хяналтын талбайн хашаа
- Гэрэлт цамхгууд /тусгай зориулалтын/
- Бохирын цооног
- Ажилчдын амрах байр
- Гал тогоо, угаалгын өрөө, 00-н хэсэг
- Агуулах
- Гараж засварын цех
- Авто зогсоол

Үүнээс 2025 онд бид гаалийн хяналтын нүүрс буулгах талбайн ажилчдын байр нь ариун цэврийн өрөө-1, техникийн өрөө -1, ажилчдын хувцас солих өрөө-1, гаалийн өрөө 1, талбайн эрхлэгчийн өрөө-1, хурлын өрөө-1, ажилчдын өрөө-1, ХАБЭА-н өрөө-1, 2 агуулахтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 10. Гаалийн хяналтын талбайн оффис, захиргааны байр

Мөн интернэт болон харилцаа холбооны асуудлыг уг салбартаа тэргүүлэгч компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан шилэн кабелын систем ашиглан шийдвэрлэсэн.

Зураг 11. Мобинет

Гаалийн хяналтын талбай дээр ухаалаг түгжээ, электрон лац, смарт картаас бүрдсэн смарт систем нэвтрүүлсэн.

Зураг 12. Авто пүүний ухаалаг гарц

Ус хэрэглээний эх үүсвэр: Унд, ахуйн зориулалтаар ашиглах усны хэрэглээг зөөврийн усаар хангана. Усны хангамж нь ойр байрлах суурьшлын бүсэд байгаа гүний худгаас зөөвөрлөдөг.

Зураг 13. Ахуйн хэрэглээний усаар хангадаг зөөврийн худаг

Оффисын болон ажилчдын ундны усыг савласан цэвэр усаар хангадаг.

Зураг 14. Савласан цэвэр ус ашиглалт

Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Талбайн гэрэлтүүлэг болон дотоодын хэрэгцээг УБТЗ-ын харьяа цахилгаан дамжуулах агаарын шугамнаас салаалж дэд станц байгуулан “УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ ЭРЧИМ ХҮЧ УС ХАНГАМЖИЙН 2-Р АНГИ-тай цахилгаан эрчим хүчээр хангах 2900987 тоот дугаартай гэрээг 2023 оны 07-р сарын 21-ны өдрөөс 2026 оны 07-р сарын 21-ны өдөр хүртэл 3 жил хугацаатай байгуулсан.



"УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ"
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
ЭРЧИМ ХҮЧ УС ХАНГАМЖИЙН II АНГИ

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ДУГААР 2900987
ХЭРЭГЛЭГЧИЙН КОД 2900987
ХЭРЭГЛЭГЧИЙН НЭР Дуут нуур хөгжил ХХК

Чойр ЦШСХ

Цахилгаан эрчим хүчний мэдээлэл лавлагаа

Чойр ЦШС-ний хэсэг:	02542-40316
Айраг ЦШС-ний хэсэг:	025241-4383
Сайншанд ЦШС-ний хэсэг:	02522-42406
Улаан-Уул ЦШС-ний хэсэг:	025254-4435
Замын-Үүд ЦШС-ний хэсэг:	025245-43475
Факс:	0252242683

Зураг 15. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ

Дулаан хангамж: : Дулаан хангамжийн эх үүсвэрийг сонгохдоо бүс нутгийн цаг уурын үзүүлэлт, оффисын барилгын овор хэмжээ, дулаан хэрэглэгчид болон тэдгээрийн үндсэн зориулалт тавигдах шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ. Ажилчдын оффис бүрт халаагч тосон тень, халуун хүйтнээр үлээдэг кондешин байрлуулсан.

Зураг 16. Дулаан хангамжийн эх үүсвэр

Хүний нөөц. Хяналтын талбайн ажилчид ажлын байрны онцлогоос хамаарч өдрийн 12 болон 8 цагаар хоногт 1-ээс 3 ээлжээр ажиллаж, 24 цагийн харуул хамгаалалт болон хяналтын камертай ажиллаж байна.

Одоогийн байдлаар хүний нөөцийн хувьд талбайн эрхлэгч 1, талбайн зохицуулагч /ХАБЭА-н ажилтан 1, ковш оператор 2, пүүний оператор 1 гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр нэг ээлжиндээ үйл ажиллагаа явуулж байна.

Гаалийн байгууллага, ачаа тээвэр болон гаалийн хяналтын бүсийн ажилчдын аюулгүй байдлыг хангахын тулд бүрэн хяналтын камерын систем болон гэрээт харуул хамгаалалтын албаар хариуцан ажиллах гэрээ байгуулан ажилладаг.

Харуул хамгаалалт: “Бамбайт гэрэгэ” ХХК харуул хамгаалалтын компанитай гэрээний дагуу ажиллаж байна. Тус компани нь 3 харуул 1 харуулын даргатай ажиллаж байна.

Зураг 17. Харуулын байр

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай” төслийн Нүүрс тээвэрлэх, ачих, буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх ажлын үед тоос, тоосжилт үүсэхээс сэргийлж тоосжилт бууруулах хашааг тогтмол засварлаж, бүрэн бүтэн байдалд хяналт тавин ажиллаж байна.

Зураг 18. Салхинаас хамгаалах хашаа засварласан байдал

Зам талбайн усалгааны зориулалтын автомашинтай болж тоосжилт үүсгэж буй зам талбайн тоосжилтыг дарах усалгааг Вагон ачилтын 80 м өргөн, 380 м урттай 2 талын талбай /6 га/ болон 4 м өргөн, 800 м тээврийн зам /0.3 га/ талбайд усалгаа хийж байна.

Зураг 19. Усалгааны машин, зам талбай усалж буй байдал

Эзэмшил талбайн дундах зам, нүүрс ачих буулгах талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар 5 км/цагаар тогтоож (шороон замд 20-40 км/цаг-с хэтрүүлэхгүй) шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлсэн.

Зураг 20. Төслийн талбайн тэмдэг тэмдэглэгээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төсөлд ашиглаж буй машин механизмууд, тээврийн хэрэгслийн тохиргоо үйлчилгээг байнга хийж жил бүрийн техникийн үзлэг оношлогоонд хамруулж агаарын бохирдлын төлбөрийг төлж ажиллаж байна.

Татвар, хураамж

Төлөөгүй | Төлсөн

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар 7173УР
Загвар Qingzhou SEM655D
Үйлдвэрлэсэн он 2021

Он	Дэлгэрэнгүй			Нийт дүн	Төлөв
2025	АТБӨЯХТатвар: 42,000 ₮	АБТөлбөр: 19,000 ₮	АЗАТөлбөр: 150,000 ₮	211,000 ₮	Төлөгдсөн
2024	АТБӨЯХТатвар: 18,000 ₮	АБТөлбөр: 9,500 ₮	АЗАТөлбөр: 60,000 ₮	87,500 ₮	Төлөгдсөн
2023	АТБӨЯХТатвар: 18,000 ₮	АБТөлбөр: 9,500 ₮	АЗАТөлбөр: 60,000 ₮	87,500 ₮	Төлөгдсөн
2022	АТБӨЯХТатвар: 18,000 ₮	АБТөлбөр: 9,500 ₮	АЗАТөлбөр: 60,000 ₮	87,500 ₮	Төлөгдсөн

Зураг 21. 7173 УР дугуйт ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр

Татвар, хураамж

Төлөөгүй | Төлсөн

Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар 7174УР
Загвар Qingzhou SEM655D
Үйлдвэрлэсэн он 2021

Он	Дэлгэрэнгүй			Нийт дүн	Төлөв
2025	АТБӨЯХТатвар: 42,000 ₮	АБТөлбөр: 19,000 ₮	АЗАТөлбөр: 150,000 ₮	211,000 ₮	Төлөгдсөн
2024	АТБӨЯХТатвар: 18,000 ₮	АБТөлбөр: 9,500 ₮	АЗАТөлбөр: 60,000 ₮	87,500 ₮	Төлөгдсөн
2023	АТБӨЯХТатвар: 18,000 ₮	АБТөлбөр: 9,500 ₮	АЗАТөлбөр: 60,000 ₮	87,500 ₮	Төлөгдсөн
2022	АТБӨЯХТатвар: 18,000 ₮	АБТөлбөр: 9,500 ₮	АЗАТөлбөр: 60,000 ₮	87,500 ₮	Төлөгдсөн

Зураг 22. 7174 УР дугуйт ачигчийн үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ

1. Тээврийн хэрэгслийн улсын дугаар:	**2461УКУ**
2. Тээврийн хэрэгслийн арлын дугаар:	**L3LH5K5U9RR179420**
3. Тээврийн хэрэгслийн загвар:	**CHUSENG CSC5250GSSD3**
4. Гэрчилгээний дугаар:	**5569331**
5. Татвар төлөгчийн дугаар:	**75000871948**
6. Татвар төлөгчийн нэр:	**ВИНТРАК ГХО ХХК**
7. Харьяалагдах татварын алба:	**Нийслэл аймгийн татварын алба**
8. Гүйлгээний огноо:	**2025-09-02 12:15:19**
9. Төлсөн дүн:	**267,000.00₮**
10. Тайлант хугацаа:	**2025**

Нэхэмжлэхийн дугаар	Татварын төрөл	Төлсөн дүн
1250404827628	Автын агаарын бохирдлын төлбөр	19000
1250404827727	Зам ашигласны төлбөр	200000
1250404827685	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	48000

Шалгах мэдээлэл:

Эх сурвалж: itax.mta.mn

Зураг 23. 2461 УКУ усны машины үзлэг оношлогоо, агаар бохирдуулсны төлбөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн А/199 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам”, Авто тээврийн тухай хуулийн 17-р зүйлд зааснаар Автотээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд жилийн турш техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно гэж заасны дагуу “Дуут нуур хөгжил” ХХК-ийн нүүрс ачиж буулгах гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгсэл, автомашинуудыг үзлэг оношлогоонд хамруулсан болно.

Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байж, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийж, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулан ажиллаж байна.

Зураг 26. Ахуйн хог хаягдлын цэг

2.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Хог хаягдлаар газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдохоос урьдчилан сэргийлж хаягдлын цэгийг 2 байршилд стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийж ашиглалтанд оруулсан.

Зураг 24. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав, бункер

Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсэх шатанд нь ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хаягдлыг дахиварын үйлдвэрт тушаахаар зориулалтын түр хадгалах саванд хадгалж, боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Бохирын цооногоор дамжин хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох журмын дагуу бохирын цооногийн септик системийн тохижуулалтыг хийж ахуйн бохир усны септик системийн байнгын бүрэн бүтэн байдал, үйл ажиллагаанд анхаарч ажиллаж байна. “Дуут нуур хөгжил” ХХК-ийн Гаалийн хяналтын талбайд ажилчдын тоо, хүчин чадалд

тохируулан “Алтай эколос” ХХК-ийн эколос 6 пр септик систем, бага оврын цэвэрлэх байгууламжийг сонгон суурилуулж ашиглаж байна.

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн төслийн талбайн газрын гадарга, хөрс элэгдэл эвдрэлд өртөхөөс хамгаалж автомашины зам, зогсоолыг дагтаршуулж, усалгаа хийж ажиллав.

Зураг 258. Авто машины зогсоол, усалгаа, дагтаршуулсан байдал

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулж бэлдсэн болно.

Зураг 3026. Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэг

Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулж ангилан хадгалах нөхцлийг бүрдүүлэн түр хадгалж байна.

2.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт

Ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төслийн талбайд 300ширхэг мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн.

Хүн болон машин механизмуудын замбараагүй хөдөлгөөнөөс болоод ургамлан нөмрөг доройтохоос сэргийлж үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох төслийн талбайд явган хүний болон машин техникийн хөдөлгөөний зам, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлж, даган мөрдөж байна.

Зураг 27. Хориглох тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал

2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт

Төслийн талбай, барилгын эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдах, гүний усанд бохирдол үүсэхээс сэргийлэх зорилгоор Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсанаар унд, ахуйн хэрэглээний усан хангамж, унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байна. Лабораторийн шинжилгээний үр дүн болон дэлгэрэнгүй мэдээллийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсгээс харна уу.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах Гаалийн хяналтын талбайд орчны тохижилт, барилга байгууламж нэмж байрлуулахдаа дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах, хатуу, шингэн хог хаягдлыг хэт хуримтлуулахгүй байж хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гэрээний хэрэгжилтийг ханган ажиллав. Хог хаягдлын мэдээллийг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн бүлэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

Зураг 28. Төслийн талбайд байршуулсан гэрэлтүүлэг

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрын 10%-иас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж зүлэгжүүлэх шаардлага, Газрын тухай хуулийн 56.6 заалт, 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд ачилт буулгалтын талбайд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлын хүрээнд мод тарих гэрээгээр “Грийн Зоне Солюшн” ХХК-р 2025 оны 10-р сард 570 ширхэг хайлаас модны тарилт суулгасан.

Зураг 33. Төслийн талбайд мод тарьж буй зураг

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт нийтийн эзэмшлийн талбайн заасан байршлын 1,5 га талбайд 1,5 метрээс дээш өндөртэй 2700 ширхэг хайлаас мод тарьсан.



GZS

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
НУТАГТ МОД ТАРИХ АЖИЛ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

Говьсүмбэр аймаг 2025 оны 10-р сарын 17-ны өдөр

Нэг талаас Захиалагч гэх **"Дуут нуур хөгжил" ХХК** (РД:6709672), нөгөө талаас Гүйцэтгэгч гэх **"Грийн Зоне Солюшн" ХХК** (РД:6576397) нарын хооронд**ын "Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт мод тарих ажил" DNKH-018** тоот гэрээний дагуу

- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт заасан байршлын 1.5 га талбайд 1.5 метрээс дээш өндөртэй 2700 ширхэг хайлаас модны тарилт,
- Гаалийн хяналтын талбайд 570 ширхэг хайлаас модны тарилт гүйцэтгэн хүлээлгэн өгч энэхүү актыг үйлдэн гарын үсэг зурав.

DNKH-018 тоот гэрээний Хавсралт №1-д заасан гэрээт ажлын шаардлагын дагуу мод тарих ажлыг 2025.10.15-ны өдрөөс 2025.10.17-ны хооронд гүйцэтгэсэн болно.

ХҮЛЭЭН АВСАН :
ЗАХИАЛАГЧ ТАЛААС:

"ДУУТ НУУР ХӨГЖИЛ" ХХК-ИЙН ТАЛБАЙН ЭРХЛЭГЧ:

Б.БАТБОЛД

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:
ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛААС:

"ГРИЙН ЗОНЕ СОЛЮШН" ХХК-ИЙН ОЙН ИНЖЕНЕР:

Б.ТЭЛМЭН

"ГРИЙН ЗОНЕ СОЛЮШН" ХХК, Утас: 99990677, 99717548

Зураг 34. Нийтийн эзэмшлийн талбайд мод тарьсан зураг

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын хэвлий бохирдох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах зорилгоор нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайн гадна, дотор талбайд Цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж ажиллаж байна.

Зураг 34. Бүх нийтийн хог цэвэрлэгээ хийж буй байдал

ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлж байх явцад олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагааг түр зогсоож, Сүмбэр сумын цагдаа, сумын засаг дарга, соёлын өвийн судалгааны байгууллагад мэдэгдэнэ гэж төлөвлөсөн бөгөөд “Дуут нуур хөгжил” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбайд одоогоор түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй болно.

ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн осол гарч болзошгүй бөгөөд гол төлөв хүмүүсийн өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэн гардаг. Энэ нь машин техник, тоног төхөөрөмжүүдтэй харьцаж ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйл ажиллагааны хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг онцгой анхаарч ХАБЭА-н тухай хууль, MNS 4969:2000 стандарт, Гэр бүл, нийгмийн хамгаалалын сайдын А/130 тушаал ХАБЭА-н сургалт зохион байгуулах журмын хэрэгжилтийг ханган нийт ажилтнууддаа ХАБЭА-н мэдлэг олгох сургалтыг тогтмол хийж хэрэгжүүлж ажиллаж байна.

5.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Байгалийн гамшгийн улмаас ажилчдын эрүүл мэнд, техник тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүчтэй салхи шуурга, аянга цахилгаантай бороо орох үед үйл ажиллагааг түр зогсоож ажиллахаар төлөвлөсөн бөгөөд одоогоор үйл ажиллагаа эхлэсэнээс хойш хүчтэй салхи шуурга болон онцгой нөхцөл үүсээгүй байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу нийт ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор сургалт зохион байгуулж, эрх үүргийг танилцуулж ажилладаг.



Зураг 29. Сургалтанд хамрагдсан ажилтнууд

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдлээс сэргийлэх төлөвлөгөөний байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, байгалийн гамшиг

гарсан тохиолдолд авах арга хэмжээний биелэлтийг хангах зорилгоор Гаалийн хяналтын талбайн ажилчдад Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан.



Зураг 30. Зааварчилгааны бүртгэлийн хуудас

5.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Төслийн талбайд цахилгаан үүсгүүр болон тамхины цог зэргээс гал түймэр гарч болзошгүй бөгөөд гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулж галын хорыг байнга шалгаж, цэнэглүүлж ажиллаж байна.

Зураг 31. Галын сарай, гал унтраах багаж хэрэгсэл байрлуулсан байдал

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 29 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 2023038

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: Дорж нуур лого ХХК

Хаяг: Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 1-р баг

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

Нүүрс ашиг бусгах талбай

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4/
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7/

Олгосон: 2024 он . 2 . сар . 21 . өдөр

Хүчинтэй хугацаа: 2026 он . 2 . сар . 21 . өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

Говьсүмбэр аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

дарга Ерөнхий цолтой Н. Сарантуяа

Дүгнэлт гаргасан:

Говьсүмбэр аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

Гал түймрийн улсын хяналтын байцаагч: цолтой

Зураг 32. Галын аюулгүй байдлын дүгнэлт

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Онцгой байдлын газраар Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг нүүрс ачилт буулгалтын талбайн обьектод 2024 оны 02-р сарын 21-ний өдрөөр 2026 оны 2-р сарын 21-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар гаргуулсан.

5.3. Осол эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Болзошгүй осол, саатал, техник тоног, төхөөрөмжийн гэнэтийн аюул үүсэх болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, барилгын үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэхээс урьдчилан сэргийлж ажилчдыг ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд өдөр тутам тогтмол хамруулан ажиллаж байна.



Зураг 33. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны бүртгэл

Зураг 34. ХАБЭА-н зааварчилгаа өгч буй байдал

Тээврийн хэрэгслийн шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг хийлгэсэн байх, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанд хэрэглэхээр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж, хянаж, бүртгэл хөтлөн ажилладаг.





Зураг 35. Техник ашиглалтын паспорт, техникийн үзлэг, үйлчилгээний тэмдэглэл

Ажилчдын эрүүл мэнд хохирохоос урьдчиан сэргийлж, яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг байршуулсан.

Зураг 36. Анхны тусламжийн хайрцаг байршуулсан байдал

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт ажилчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгож ажиллаж байна.



Хүлээлцэх хуудас

Байршил-Чойр

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Хэмжээ	Үнэ	Харьяа нэмэлт	Авилтан нэр	Хүлээн авсан гарын үсэг	Хүлээн авсан огноо:
1	Ажлын гутал	1	40	₮ 275,000	Дуут нуур хогжил ХХК	Томорбаатар		2025.06.12
2	Ажлын гутал	1	39	₮ 275,000	Дуут нуур хөгжил ХХК	Х.Мөнхбаатар		2025.06.12
3	Ажлын гутал	1	43	₮ 275,000	Дуут нуур хөгжил ХХК	Б.Арнуунжаргал		2025.06.12
4	Ажлын гутал	1	39	₮ 275,000	Дуут нуур хөгжил ХХК	Ч.Чагнаадорж		2025.06.12
5	Ажлын гутал	1	41	₮ 275,000	Дуут нуур хөгжил ХХК	Билгүүн		2025.06.12
6	Ажлын гутал	1	41	₮ 275,000	Дуут нуур хөгжил ХХК	Ө.Лхамжаргал		2025.06.12

Зураг 37. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл олгосон байдал

“Дуут нуур хөгжил” ХХК нь Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагчаар хянуулж баталгаажуулан холбогдох тодотголыг хийж гүйцэтгэн танилцуулж ажилладаг.



БАТЛАВ
ДУУТ НУУР ХӨГЖИЛ ХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Т.ТӨРМӨНХ
2023оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

ДУУТ НУУР ХӨГЖИЛ ХХК-НЫ ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ
АХМАД С.ЭНХ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН: ХАБЭА-н АЖИЛТАН М.ЧАГНААДОРЖ

Зураг 38. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

2025 онд тохиолдож болзошгүй гамшгийн аюулын шалтгаан, түүний хамрах хүрээ, гарах хүндрэл, цаг уурын нөхцөл, тохиолдох давтамжийн магадлал, учруулах хор уршиг, аюулд өртөгдөх зүйл, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн баталгаа, аюулгүй ажиллагааны системийн удирдлага зохион байгуулалт, гамшгаас учирч болох нийгэм, эдийн засгийн болзошгүй үр дагаврыг үнэлэх зорилгоор Гамшгийн эрсдлийн үнэлгээг “Уст бэлчир” ХХК-р гэрээний дагуу гүйцэтгүүлсэн болно.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Хийх ажил	Хугацаа	Арга чилал	Харнуулах эзэн
“Дуут Нуур Хөгжил” ХХК-ийн Говьсүмбэр салбарын нөхцөл байдалтай танилцах газар оронд үзлэг хийж, үнэлэх.	2025 оны 3 дугаар сарын 06-11-ны хугацаанд	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар”, Эрсдэлийн менежмент-зарчим ба заавар MNS ISO 31000:2015, Онцгой байдлын ерөнхий газрын дарга “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 2021 оны А/255 дугаар тушаалыг мөрдлөг болгоно. Fenix программ хангамжаар fire dynamic simulation гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийдэг Аюул, эмзэг байдал, эрсдэлийн нөхцөл байдлыг ArcGIS программ хангамжаар газар зүйн мэдээллийн системд зураг оруулдаг.	Багийн бүрэлдэхүүн
Холбогдох материал бүрдүүлж, гал түймэр, газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүн, малын гоц халдварт зооноз өвчний эрсдэлийн үнэлгээ хийх	2025 оны 3 дугаар сарын 11-ны өдрөөс 4 дүгээр сарын 02-ны хугацаанд		
“Дуут Нуур Хөгжил” ХХК-ийн Говьсүмбэр салбарын гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах	2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөс 5 дугаар сарын 05-ний хугацаанд		
“Дуут Нуур Хөгжил” ХХК-ийн Говьсүмбэр салбарын гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланг дүгнэж хүлээлгэн өгөх	2025 оны 5 дугаар сарын 06-ны өдөр		

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“ДУУТ НУУР ХӨГЖИЛ” ХХК-ИЙН
ХАБЭА-Н АЛБАНЫ ДАРГА
..... Г.ИТГЭЛ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“УСТ БЭЛЧИР” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..... Ч.ЛХАМЖАВ

Зураг 39. Гамшгийн эрсдлийн үнэлгээ

ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах “Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллаж байна.

6.1. Энгийн хог хаягдлын менежмент

6.1.1. Хатуу хог хаягдал

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь цаасны хаягдал, хуванцар хаягдал, бусад гэж 3 ангилан цуглуулж, нэгдсэн нэг хогийн цэг дээрх хогийн саванд түр хадгалдаг.

Зураг 40. Хогийн сав (Цаас, хуванцар, бусад)

Энгийн хатуу хог хаягдлыг зайлуулах гэрээг Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай байгуулж, гэрээний дагуу ачуулж зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байна.

Зураг 41. Гадна талбайн ангилдаг хогийн бункер

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэргийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.





Д/д	Огноо	Хогны машины дугаар	Хогны хэмжээ	Хог ачсан ажилтаны нэр	Хянасан ажилтаны нэр
1.	2025 05.05	16-65 ГСА	3 м.куб		
2.	05.07	16-65 ГСА	3 м.куб		
3.	2025 07.27	61-30 ГСА	3		Х. Монхбаатар
4.	08.23	61-30 ГСА	250 кг		Х. Монхбаатар
5.	09-20	61-30 ГСА	300 кг		Х. Монхбаатар
6.					
7.					
8.					
9.					
10.					
11.					
12.					
13.					
14.					
15.					

Зураг 42. Хог хаягдлын гэрээ, ачилтын бүртгэл

6.1.2. Ахуйн шингэн хаягдал

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн Гаалийн хяналтын талбайд ажилчдын тоо, хүчин чадалд тохируулан “Алтай эколос” ХХК-ийн эколос 6 пр септик систем, бага оврын цэвэрлэх байгууламжийг сонгон суурилуулж ашиглаж байна.

Зураг 43. Эколос 6 ПР септик систем суурилуулалт

Хүснэгт 2. Техникийн үзүүлэлт

1	Хэрэглэгчийн тоо	6 хүн
2	Багтаамж	1150 л
3	Хүлээн авах камерт 2 цагт орох дээд хэмжээ (литр)	(250 цагт)

Энэхүү бага оврын цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь 1.15 $м^3$/хон, хэрэглэгчдийн тоо 6 хүн, хоолойн гүн 60 м, эрчим хүчний хэрэглээ 1.6 кВт/хон, жин 250 кг.

Хүснэгт 3. Хэмжээнүүд

№	Хэмжээ	Үзүүлэлт
1	Урт	1080
2	Өргөн	1170
3	Өндөр	2600
4	Жин	250

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 00515

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг тус тус үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянгол сум /дүүргийн "АЛТАЙ ЭКОЛОС" ХХК-д

9011793054 6411851

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заагдсан Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Зохицуулах Зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 144 тоот тогтоолыг үндэслэн 3 /гурав/ жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

Тусгай зөвшөөрөл

Олгосон огноо: 2021-12-27 Дуусах огноо: 2024-12-27

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ж.БАЯСУУРЬ

2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр
Улаанбаатар хот

0009258

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар БУ11-861/21

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Баянгол сум/дүүргийн "Алтай эколос" ХХК-д

9011793054 6411851

БА-2.1, БА-3.4, БА-6.1, БА-6.2, БА-8.3, БА-7.1 зааалтын дагуу

ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 10 -р сарын 06 -ны өдрөөс 3 жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Б.МӨНХБААТАР

2021 оны 10 сар 06 өдөр
Улаанбаатар хот

Зураг 44. Алтай эколос ХХК-ийн тусгай зөвшөөрөл

Говьсүмбэр аймгийн байгаль орчны газраас зохион байгуулсан хог хаягдлын сургалтанд 2025 оны 07-р сарын 9-ний өдөр хамрагдсан болно.



Зураг 45. Хог хаягдлын сургалтанд хамрагдсан байдал

6.2. Аюултай хог хаягдлын менежмент

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний аюултай хог хаягдлын менежментэд тусгаснаар аюултай хог хаягдлын цэг байгуулж, машин техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан эрх бүхий дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөсөн.

Зураг 46. Аюултай хог, хаягдал түр хадгалах талбай

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу автомашины зогсоол, нүүрс ачих буулгах талбайн орчинд машины сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж сэлбэг хэрэгсэл, дугуйн хаягдлыг тусгаарласан хашлага бүхий тусгай талбайд хуримтлуулахаар төлөвлөн суурь бэлдэж, аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулсан.

Хүлээлцэх хуудас 交接单

Хаанаас явуулсан: 发货地点
Хаана хүргэгдсэн: 到货地点
Хүлээлцэх дугаар:订单号

Улаанбаатар
Чойр
XX0602

№	Нэр төрөл类别	Тоо ширхэг 数量	Үнэ价格	Нийт үнэ 总计	Харьяа компани: 属于公司	Нийлүүлэгч/供应商
1	Аюултай хог хаягдлын цэг	1	2,090,909	2,090,909.1	Дуут нуур хөгжил ххк	Тунамал шийдэл ххк
	Нийт	1		2,090,909.09		

Явуулсан发送: Тэмүүлэн
Хүргэлт гарсан огноо: 发送时间 2025 06.05

Хүлээн авсан已收到: Чагнаадорж
Хүлээн авсан огноо: 收到时间 2025.06.06

Зураг 47. Аюултай хог хаягдлын цэгийн хүлээлгэн өгөх хуудас

Гаалийн хяналтын үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлын бүртгэл хөтөлж, зориулалтын түр хадгалах цэгт хадгалж байгаа бөгөөд аюултай хог хаягдал үүсгэгчийн Y дугаар авсан болно. Холбогдох материалыг хавсралт хэсгээс харна уу.

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан мониторингийн цэгүүдэд үндэслэн 2025 оны мониторинг хийх цэг, үзүүлэлтүүдийг дараах байдлаар сонгон авч хэмжилт дээжлэлтүүдийг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил

Цэгийн дугаар	Байршил	Солбицол*	
		X	Y
Агаар 1	Ачилт буулгалтын талбайд	108^0 20’ 31.034”	46^0 20’ 35.209”
Хөрс 1	Төслийн талбайд	108^0 20’ 33.111”	46^0 20’ 43.572”
Хөрс 2	Авто зогсоолын ойролцоо	108^0 20’ 30.986”	46^0 20’ 37.266”
Ус	Харуулын байр	108^0 20’ 32.945”	46^0 20’ 37.706”

*Тайлбар: *-Солбицолын тогтолцоо WGS84 UTM Zone49*

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт байрлах ачилт буулгалтын талбайн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгийн байршлыг дараах зургаар харууллаа.



Зураг 48. Мониторингийн цэгүүдийн байршил

7.1. Агаарын чанарын хяналт, шинжилгээ

7.1.1. Судалгааны аргазүй

7.1.1.1. Хээрийн судалгаа

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн нүүрс ачилт буулгалтын гаалийн хяналтын талбай орчмын агаарын чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хээрийн судалгааг 2025 оны 4-р сар болон 9-р сард, жилд 2 удаа хийж гүйцэтгэсэн. Энэхүү төслийн талбайн агаарын чанарын

мониторинг хийх гадаад орчны 1 цэгт тоос, азотын давхар исэл, хүхэрлэг хий, шуугианы дээжлэлт, хэмжилт хийв. Дээжийг авахдаа “Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 3384:1984” стандартыг баримталсан. Утааны хийг агаарын хяналт шинжилгээний цэгийн орчмын агаараас 2л/мин хурдтайгаар 20 минутын турш шингээгч гуурсанд соруулсан бол нийт тоосыг DustTack 8530 багажаар, дуу шуугианыг JEIC Type 1015 загварын зөөврийн багажаар тус тус хэмжив.

Зураг 49. Хээрийн судалгааны багаж

Хүхэрлэг хий. Төслийн талбай орчмын агаараас 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд соруулахад шигээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлно.

Азотын давхар исэл. Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын туршсоруулан авахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфаналины хүчилтэй харилцан үйлчилж диазо нэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь α - нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.

Тоос. Агаар дахь тоосны агууламжийг DustTrak Monitor II Model 8530 гэх зөөврийн автомат багажаар тодорхойлсон бөгөөд энэ багаж нь агаар дахь PM10, PM2,5, PM1.0 хэмжээтэй тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг хэмжинэ.

Агаарт агуулагдаж байгаа тоосыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар соруулан оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн саринал тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй агаар дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдагт тулгуурласан.

7.1.1.2. Лабораторийн задлан шинжилгээ

Утааны хийн дээжнүүдэд лабораторийн задлан шинжилгээг MNS 0017-2-5-11:1988 “Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга”, MNS 0017-2-5-12:1988 “Агаар мандал. Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга”-уудыг ашигласан байна.

7.1.1.3. Зураглал

Агаарын мониторингийн цэгийн байршилын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.1 программын тусламжтай хийж гүйцэтгэв.

Хүснэгт 5. Агаарын чанарын мониторингийн цэг /Гадаад орчин/

д.д	Солбицол		Цэгийн нэр	Байршил
	Х	У		
1	108^0 20’ 31.034’’	46^0 20’ 35.209’’	А-1	Ачилт буулгалтын талбайд



Зураг 50. Агаарын мониторингийн цэг



Зураг 51. Агаарын чанарын шинжилгээ хийсэн хэсэг /4 болон 9-р сар/

7.1.2. Судалгааны үр дүн

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн төслийн талбай нь Говьсүмбэр сумын Сүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд төслийн талбай орчмын агаарын чанарыг тодорхойлох зорилгоор агаарын чанарын шинжилгээ хийсэн болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторит шинжилсэн агаарын чанарын сорилтын 2025 оны 4-р сар болон 9-р сарын үр дүнг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6. Агаарын шинжилгээний лабораторийн сорилтын дүн

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэгхий мг/м^3	Азотын давхар исэл мкг/м^3	Нийт тоосны агууламж /TSP/, мкг/м^3	Дуу чимээ /ДБА
“Дуут нуур” ХХК, Гаалийн хяналтын талбай							
2025 оны 4-р сар							
1	Ачилт буулгалтын талбай	**IV/10**	11:30	0.006	0.028	0.441	52
2025 оны 09-р сар							
1	Ачилт буулгалтын талбай	**IX/09**	11:40	0.012	0.025	0.229	62
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				**0.450**	**0.200**	**0.500**	**60**

Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор хүрээлэн байгаа агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээг тогтоосон стандартын үзүүлэлттэй гаалийн хяналтын талбайн гадна агаарын

сорилтын дүнг харьцуулахад агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж нь сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байгаа болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторит шинжилсэн агаарын чанарын сорилтын дүнг хавсралт хэсэгт оруулав.

7.2. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ

7.2.1. Судалгааны аргазүй

7.2.1.1. Хөрсний хээрийн судалгаа

Гаалийн хяналтын талбайн хөрсний мониторингийн хээрийн судалгаа буюу хөрсний дээж авалтыг 2025 оны 4 болон 9-р сард хийж гүйцэтгэсэн. “Дуут нуур хөгжил” ХХК-ийн хөрсний мониторинг хийх нийт 2 цэгээс өнгөн хөрсний буюу 0-20 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдолын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298 : 1990” стандартыг баримталсан.

7.2.1.2. Лабораторийн задлан шинжилгээ

Хөрсний дээжнүүдэд агро-химии, физик шинж, хүнд зэрэг үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. *Хөрсний агрохимийн шинж* чанарын үзүүлэлтүүдийг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан болно. Үүнд:

- Ялзмаг - Тюриний
- Урвалын орчин (pH) - Потенциометрийн
- $CaCO_3$ карбонат - Кальциметрийн
- Механик бүрэлдэхүүн - Гидрометрийн
- Давсжилт, EC - Потенциометрийн
- Фосфор - Спектро фотометр
- Кали - Дөлт фотометр

Хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд бэлтгэж боловсруулахад “Физик химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах. MNS ISO 11464:2002” стандарт, анализ хийхэд “Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310:1991” стандартуудыг мөрдлөг болгосон байна.

7.2.1.3. Зураглал

Хөрсний мониторинг цэгийн байршлын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.1 программ дээр хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг А4 хуудсан дээр 1:14000 масштабтай бэлдсэн.

Хүснэгт 7. Хөрсний мониторингийн цэгийн солбицол

№	Мониторинг цэг	Ерөнхий байршил	Цэгийн солбилцол	
			Y	X
1	S1	Төслийн талбайд	108^0 20’ 33.111”	46^0 20’ 43.572”

2	S2	Авто зогсоолын ойролцоо	108^0 20’ 30.986”	46^0 20’ 37.266”



Зураг 52. Хөрсний мониторингийн цэгийн байршил

7.2.2. Судалгааны үр дүн

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн Гаалийн хяналтын талбайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, талбайн хөрсөн бүрхэвчийн шинж чанарыг тодорхойлох зорилгоор төслийн талбайгаас өнгөн хөрсний дээжлэлт хийж хөрсний химийн үндсэн шинж, хөрсний механик бүрэлдэхүүн, хөрсний хүнд металл тодорхойлох шинжилгээг Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн болно.

“Дуут нуур хөгжил” ХХК-ийн төслийн талбайгаас авсан хөрсний дээжлэлтүүд хийсэн хэсгийг дараах зургаар харууллаа.

Зураг 53. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Төслийн талбайн голд 4-р сар болон 9-р сар/

Зураг 54. Хөрсний дээжлэлт хийсэн цэг /Авто зогсоолын ойролцоо 4-р сар болон 9-р сар/

Хөрсний химийн үндсэн шинж. Гаалийн хяналтын талбайгаас авсан өнгөн хөрсний химийн үндсэн шинжийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 8. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	pH	Давс %	ЦДЧ	$CaCO_3$ %	Ялзмаг %	Шингээгдсэн суурьууд, мг-экв/100гр		Шим тэжээлийн элемэнтүүд мг/100гр	
							Ca	Mg	P_2O_5	K_2O
2025.4-р сар, гүн 0-20см										
1	Авто машины зогсоол	8.01	0.04	0.081	0.33	0.87	14.0	1.5	0.7	11
2025.9-р сар, гүн 0-20см										
2	Авто машины зогсоол	9.10	0.06	0.117	0.00	2.17	10.6	8.8	2.5	15
3	Ачилт буулгалтын талбай	8.74	0.03	0.051	0.00	1.78	10.4	8.0	4.8	22

